# АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран ажиллах байгууллага | Шаардагдах төсөв |
|---|---|---|---|---|---|
| Нэг. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг боловсронгуй болгож мэдээлэлийн нэгдсэн сүлжээг өргөжүүлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн нарийн мэргэжлийн мэдлэг ур чадвартай ажилтан бэлтгэх, давтан сургах | | | | | |
| 1.1 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, МСҮТ, их дээд сургууль төгсөгчдийн судалгааг гаргаж мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж, аймгийн Мэргэжлийн боловсрол сургалтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, МСҮТ-ийн захирал | СЗДТГ, БСУГ, АОЭХ | - |
| 1.2 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн тогтолцоог бусад салбарын мэдээллийн сантай уялдуулан мэдээлэл солилцох, хянах түгээх боломжийг бүрдүүлэх | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, МСҮТ-ийн захирал | СЗДТГ | - |
| 1.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадавхийг тодорхойлох судалгааг гаргах | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, АХБИХолбоо | ЭМНДХ, СЗДТГ | - |
| 1.4 | Хөдөлмөрийн биржээр дамжуулан иргэдийг ажилд зуучлах, зөвлөгөө өгөх үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх, цахим хэлбэрээр мэдээллийн баазыг үүсгэн бүх сумдад цахим биржийг суурилуулах | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, СЗДТГ | АОЭХ | - |
| 1.5 | Ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй, эмзэг бүлгийн иргэдийг аймгийн МСҮТ болон бусад бизнесийн төвүүдтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хэрэгцээ, мэргэжил, ур чадвар, хүсэл сонирхолыг харгалзан "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллах | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, МСҮТ-ийн захирал | СЗДТГ, ААХ, АОЭХ, АХБИХ, АЭХ | ХЭДС |
| 1.6 | Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элсэгчдийг бүртгэх, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэх; | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, МСҮТ-ийн захирал | СЗДТГ | ХЭДС |
| 1.7 | МСҮТ-д суралцагсдын үйлдвэр дээрх дадлага хийх орчин нөхцлийг бүрдүүлэн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын тоног | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, Б.Эрдэнэбаатар | МСҮТ-ийн захирал | ОНХС, ХЭДС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | төхөөрөмжийг шинэчлэх, багш нарыг давтан сургах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх зэрэг ажлыг зохион байгуулах | | БСУГ-ын дарга | | |
| 1.8 | Өрх бүрийг орлоготой болгох, өрхийн бизнесийг дэмжих чиглэлээр бизнесийн боловсрол олгох сургалт сурталчилгаа явуулж, малчдын бүлэг, ойн нөхөрлөл, хоршоо зэрэг зорилтот бүлгийн иргэдийг хамруулах | 2017-2020 он | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, СЗДТГ | БОАЖГ, Бизнес инкубатор төв | ХЭДС |
| ***Хоёр. Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинээр бий болгосон ажлын байрыг тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлэх*** | | | | | |
| 2.1 | Шинэ ажлын байр бий болгох ажлын хүрээнд жил бүр 1500-аас доошгүй шинэ ажлын байр бий болгоно. | Жил бүр | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, СЗДТГ | ХОХБТХ, ХХААГ, БОАЖГ, АОЭХ | ОНХС, ХЭДС, ЖДҮДС, Байгаль хамгаалах сан |
| 2.2 | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа өрхийг дэмжин таатай орчин бүрдүүлэх чиглэлээр "Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв" байгуулах ажлыг эрчимжүүлэн бүх сумдад байгуулах | 2017-2020 он | АЗДТГ, ХХААГ | СЗДТГ | ОНХС, ХЭДС, ЖДҮДС, СХС |
| 2.3 | Хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэн, боловсруулах цех, ”Нарлаг” хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлж, “Чацаргана” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн иргэдийг ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх | 2017-2020 он | АЗДТГ, ХХҮГ, ХХААГ | СЗДТГ | ОНХС, ЖДҮДС, СХС |
| 2.4 | Аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулах, цемент, барилгын бетон хийц, өнгөлгөөний тоосго, улаан тоосго, хөнгөн блок, зуурмагны үйлдвэр зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулан ЖДҮДС-аас жижиг зээлийн дэмжлэг үзүүлэх | 2017-2020 он | АЗДТГ, ХХҮГ, ХХААГ | СЗДТГ | ЖДҮДС, ОНХС, СХС, Байгаль хамгаалах сан |
| 2.5 | Булган, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Орхон сумдын гурилын үйлдвэрүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн ажлын байрыг тогтвортой хадгалсан үйлдвэрийг урамшуулах | 2017-2020 он | АЗДТГ, ХХҮГ, ХХААГ | СЗДТГ | ЖДҮДС, ОНХС, СХС |
| 2.6 | Хүн, амын хүнсний хангамжийг хэмэгдүүлэх зорилгоор “Мах”, “Сүү” аяныг зохион байгуулан иргэдийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах | 2017-2020 он | АЗДТГ, СЗДТГ, ХХААГ | ХХҮГ | ЖДҮДС, ОНХС, СХС |
| 2.7 | Хөдөлмөр эрхлэх зорилго чиглэл, ажлын дадлага | 2017-2020 | АЗДТГ, | СЗДТГ | ХЭДС, СХС, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | туршлагаар нь нэгтгэн хоршоо, нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлж, зээл олгох / үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимгэнэ тарих, гахай тахиа үржүүлэх болон бусад чиглэлээр туслах аж ахуй/ | он | ХХҮГ, ХХААГ | | ЖДҮДС, ОНХС |
| 2.8 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн дагуу урамшуулах ажлыг зохион байгуулах | 2017-2020 он | АЗДТГ, ХХҮГ, АХБИХ | СЗДТГ | ХЭДС |
| 2.9 | Баг бүрт 1,0-2,0 сая төгрөгний “Бичил зээл”-ийн эргэлтийн санг нэмэгдүүлэх өрхийн бичил бизнесийг дэмжин зээл олгох, үр дүн тооцох | 2017-2020 | АЗДТГ, ХХҮГ | СЗДТГ | СХС, Багийн бичил зээлийн сан |
| 2.10 | Ажил олоход хүндрэлтэй иргэдийг гадаадад ажиллах хүчээр илгээж, холбон зуучлах ажлыг зохион байгуулах, төрийн албан хаагчдыг гадаадад түр хугацаагаар ажлуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх /БНӨСУ, Япон гэх мэт/ | 2017-2020 | ХХҮГ | СЗДТГ | ХЭДС |
| 2.11 | Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдэд бизнесийн тэгш боломж олгох, зээл тусламжид хамруулах, бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх | 2017-2020 он | АЗДТГ, ХХҮГ, ХХААГ | СЗДТГ, АОЭХ | ХЭДС, ЖДҮДС, СХС |
| 2.12 | Ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажлын байранд зуучлах, ажлын байрны мэдээллийг олон нийтэд хүргэх, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор “Хөдөлмөрийн яармаг”-ийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах | Жил бүр | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга | СЗДТГ | ХЭДС |
| 2.13 | Бизнесийн жишигт нийцсэн “Худалдааны битүү зах” барих, бөөний худалдааны сүлжээг өргөтгөхөд хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих | 2017-2018 он | АЗДТГ, ХБХОТХ | Булган СЗДТГ | ОНХС |
| ***Гурав. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин нийгмийн хамгааллыг сайжруулж, ”Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах*** | | | | | |
| 3.1 | Нэн ядуу, цөөн малтай болон огт малгүй өрхийг “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулж жилд 20-оос доошгүй өрхийг хамруулж, малчин өрхийн амьжиргааг дэмжих | Жил бүр | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга | СЗДТГ | ХЭДС |
| 3.2 | Ажилгүй , орлого багатай өрхийн иргэдийг туслах малчнаар ажиллуулан ажлын байраар хангасан мянгат малчидтай гэрээ байгуулан ажиллаж урамшуулал | Жил бүр | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга | СЗДТГ | ХЭДС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | олгох | | | | |
| 3.3 | Аймгийн зарим сумдын орлого багатай малчин өрхүүдээс жил бүр 1-3 өрхийг “Малжуулах төсөлд” хамруулах, малгүй иргэдийг туслах аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах | Жил бүр | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга | СЗДТГ | ХЭДС, ОНХС, СХС |
| 3.4 | Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэгчдийг нэг болон олон наст ургамлын үр, бага оврын техник тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх | 2017-2020 он | АЗДТГ, ХХААГ, | СЗДТГ | Улс, ОНХС, ХЭДС |
| 3.5 | Бүх суманд малчдын сургалтын төв байгуулж, түүгээр дамжуулан танхимын, талбайн, өрхийн сургалтуудыг явуулах, тэргүүний сайн малчдын туршлагыг эзэмшүүлэх, дагалдуулах замаар мал маллагааны уламжлалт болон дэвшилтэт арга ажиллагаанд сургаж, мэргэшүүлэх | 2017-2020 он | АЗДТГ, ХХААГ, ХХҮГ | СЗДТГ | Улс, ОНХС, ХЭДС |
| 3.6 | Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргах, хадлан тэжээл бэлтгэх, хашаа, хороо барих зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай олон нийтийг хамарсан арга хэмжээг түлхүү зохион байгуулна. | 2017-2020 он | АЗДТГ, ХХААГ, ХХҮГ | СЗДТГ | Улс, ОНХС, ХЭДС |
| 3.7 | Малчдыг нийгмийн даатгалын сайн дурын болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах ажлыг шат дараатай зохион байгуулах | 2017-2020 он | АЗДТГ, ХХААГ, ЭМНДХ | СЗДТГ | НДС |
| ***Дөрөв. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын идэвх, санаачлагыг дэмжих*** | | | | | |
| 4.1 | Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийн талаархи олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, сургалт мэдээллийн ажлыг түлхүү зохион байгуулах | 2017-2020 | Н.Батжаргал ХХҮГ-ын дарга, Аймгийн бүтээмжийн зөвлөл | АОЭХ, АҮЭХ, СЗДТГ | ОНХС, ХЭДС |
| 4.2 | Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр”-ийг суманд байгуулж, салбар хорооны гишүүдийг чадавхижуулах сургалт семинарыг зохион байгуулах | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | ХЭДС, ОНХС |
| 4.3 | Хамтын гэрээ хэлэлцээр байгуулах, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн сургалт семинарыг салбар хорооны гишүүд, удирдах ажилтнуудын дунд зохион байгуулах | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | ХЭДС, ОНХС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.4 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх мэдлэгийг иргэд олон нийтэд мэдээлэх, сургалт сурталчилгааны ажил болон үзлэг шалгалтыг жил бүр хийх, үр дүнг тооцох /мэргэжлийн баг байгуулах/ | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | ХЭДС, ОНХС |
| 4.5 | Хувийн хэвшлийн аж ахуйн байгууллагад ажиллагсадад олгож байгаа цалин хөлсний хэмжээ хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн норм, нормативийн байдалд жил бүр үзлэг хийж гурван талын хамтарсан хурлаар хэлэлцүүлж, цалин хөлсний талаар заавар зөвлөмж өгөх, олон нийтэд сурталчлах | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | ХЭДС, ОНХС |
| 4.6 | Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, хөдөлмөр эрхлэх болон бусад чиглэлээр байгуулагдсан аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ИНБ-ын төлөөлөл оролцуулан, хамтран ажиллах | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | - |
| 4.7 | Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас ажлаасаа чөлөөлөгдсөн хүмүүст шинээр мэргэжил олгох, мэргэшүүлэх, ажлын байраар хангах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгааг хангах чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөрийг тухайн салбарын түншлэгч талууд хамтран боловсруулж хэрэгжүүлэх | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | - |
| 4.8 | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн орлогоос тухайн байгууллагын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | - |
| 4.9 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн орон нутагт дэд бүтэц хөгжүүлэх, байгалийн нөхөн сэргээлт хийх, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлж, тухайн сум, орон нутгийн иргэдийг ажлын байраар ханган ажиллах чиглэлийг гурван тал хамтран холбогдох байгууллагад хүргүүлэх /тендэрийн хуулинд өөрчлөлт оруулах тухай санал гэх мэт/ | 2017-2020 | Салбар хороо, АОЭХ, АҮХ | СЗДТГ | - |